



“Замын-Үүд ”эдийн засгийн чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөг батлах тухай”

2011 оны 6 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 187

Улаанбаатар хот

“Замын-Үүд “эдийн засгийн чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөг батлах тухай Хот байгуулалтын тухай хуулийн 6.1.6-г үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.”Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөг хавсралтад заасан бүрдэлтэйгээр баталсугай.

2.”Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөнд заасан арга хэмжээ болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улс, орон нутгийн төсөвт тусган, гадаад орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа хөтөлбөрт хамруулах, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулах замаар санхүүжүүлэх ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг, Сангийн сайд С.Баярцогт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга нарт даалгасугай.

3.”Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөг Замын-Үүд сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үндсэн шийдэлтэй уялдуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд Н.Алтанхуягт үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.Батболд

Монгол Улсын Тэргүүн шадар сайд

Н.Алтанхуяг